



ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ХУРААНГУЙ (Эрүүгийн хэрэг¹)

СЭТГЭЦИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ЯВЦАД ХЭРГИЙН ТАЛААР ӨГСӨН ТАЙЛБАРЫГ НОТЛОХ БАРИМТАД ТООЦОХГҮЙ

САНАМЖ: Энэхүү хураангуй нь шүүхийн шийдвэрийг орлохгүй ба хууль хэрэглээний нэгдмэл байдлыг тогтооход дэмжлэг үзүүлэх, шүүхийн шийдвэрийн үндэслэлийг сурталчлах болон иргэд, олон нийтийн эрх зүйн мэдлэгт зориулсан бөгөөд хураангуйд ашигласан шийдвэр нь хяналтын шатны шүүхийн тогтоол болно.

Шүүхийн шийдвэрийн дугаар: 2024/ХШТ/51

Шүүхийн шийдвэрийн огноо: 2024 оны 04 дүгээр сарын 10-ны өдөр

Шийдвэрийн төлөв: Анхан шатны шүүхийн шийтгэх тогтоол, давж заалдах шатны шүүхийн магадлалыг тус тус хүчингүй болгосон.

ХЭРГИЙН ТУХАЙ ТОВЧ

Шүүгдэгч нь хохирогчтой маргалдах явцдаа түлхэж хана мөргүүлсний улмаас гавал тархины битүү гэмтэл учруулан хүнийг алсан гэмт хэрэгт холбогджээ.

ХУУЛЬ ХЭРЭГЛЭЭ, ШҮҮХИЙН ШИЙДВЭР

- Анхан шатны шүүхээс** шүүгдэгчийг хүнийг алах гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож, Эрүүгийн хуулийн тусгай ангийн 10.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт² зааснаар 9 жилийн хорих ял оногдуулсан.
- Давж заалдах шатны шүүхээс** анхан шатны шүүхийн шийтгэх тогтоолыг хэвээр үлдээж шийдвэрлэсэн.
- Хяналтын шатны шүүхэд шүүгдэгчийн өмгөөлөгчийн гаргасан гомдолдоо** "...шүүх эргэлзээ бүхий мэдүүлэг өгсөн гэрч болон шинжээч эмч нарын мэдүүлгийг үндэслэн, ноцтой зөрүүтэй хэргийн үйл баримтыг хэрхэн, яаж үнэлж дүгнэсэн талаар дүгнэлт хийлгүй хэт нэг талыг барьсан" гэжээ.
- Хяналтын шатны шүүхээс** нотлох баримтуудыг харьцуулж үзвэл зочид буудлын өрөөнд байрлах орноос хохирогчийн мөргөсөн гэх хана хүртэл 18 см зайтай байх бөгөөд энэ орон зайд хохирогчийг хүчтэй түлхэхэд оронд тээглэн дагзны зүүн доод хэсгээр хана мөргөж амь насанд аюултай хүнд гэмтэл учирсан гэхэд эргэлзээ төрүүлэхээр байна. Мөн камерын бичлэгт үзлэг хийсэн тэмдэглэлд тусгагдсан М.М нэг удаа, С.А хоёр удаа өшиглөж байгаа үйл баримт нь тухайн хэрэгт хамааралтай эсэхийг шалгаагүй, нэмэлт шинжилгээний 252 тоот дүгнэлтээр тогтоогдсон дух, зүүн хацар, баруун

¹ Шүүхийн шийдвэрийг бүрэн эхээр нь үзэх холбоос:

https://www.shuukh.mn/single_case/3579?daterange=2023-01-01%20-%202025-10-10&id=3&court_cat=2&bb=1

² Эрүүгийн хууль (2015)-ийн 10.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг "Хүнийг алсан бол найман жилээс арван таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ."



- тохой, зүүн шуу, баруун ташаа, бүсэлхий нурууны зулгаралт гэмтлүүд нь хэзээ, хаана, ямар хүчин зүйлийн үйлчлэлээр үүссэн болохыг тогтоогоогүй зэргээр мөрдөн шалгах ажиллагаа бүрэн биш хийгдсэн байна. (21)³
5. Үүнийг нотлох баримтын хүрэлцэхүйц байдал хангагдаагүй, дүгнэлтэд ноцтойгоор нөлөөлж болох нөхцөл байдлыг анхаарч үзэлгүй орхигдуулснаас хоёр шатны шүүхийн хийсэн дүгнэлт нь хэргийн бодит байдалтай нийцээгүй гэж үзнэ. (24)
 6. Сэтгэцийн шинжилгээ хийх явцад шүүгдэгч "... манай хоёр муудалцсан, би ор руу түлхсэн ..." гэж ярьсан нь шинжээчийн 272 тоот дүгнэлтэд тусгагдсан ба **шүүхээс дүгнэлтийн энэ хэсгийг хэргийн үйл баримтыг тогтоох нотолгооны эх сурвалж болгон ашигласан нь хуульд нийцэхгүй.** (25)
 7. Сэтгэцийн шинжилгээ нь хэргийн нөхцөл байдлыг бодитой тусгаж, үнэн зөв мэдүүлэг өгөх болон хэрэг хариуцах чадвартай эсэхийг тогтоох зорилго бүхий шинжилгээний онцгой төрөл бөгөөд сэтгэцийн үзлэгийн явцад тодорхой асуумжийн дагуу шинжлүүлэгчийн ярьсан зүйл нь зөвхөн тухайн шинжилгээний үр дүнд ач холбогдолтойд тооцогдохоос бус **шинжлүүлж буй хүнд өөрт нь холбогдох эрүүгийн хэргийн үйл баримт, гэм бурууг тогтоох нотолгоо байх боломжгүй.** (26)
 8. Учир нь, сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн мэдүүлгийн хууль ёсны байдал нь **өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхгүй байх** эрхийг баталгаатай эдлүүлснээр хангагдах бөгөөд сэтгэцийн шинжилгээний үзлэгийн явцад энэхүү эрхээ эдлэх боломжгүй нөхцөлд ярьсан зүйлийг түүний эсрэг нотлох баримтаар ашиглах нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 7.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг "Яллагдагч ... мэдүүлэг өгөхөөс татгалзах эрхтэй", мөн зүйлийн 2 дахь хэсэгт "Яллагдагч өөрийн эсрэг мэдүүлэг өгөх, гэмт хэрэг үйлдсэн гэм буруугүйгээ, эсхүл хэргийн байдлыг нотлох үүрэг хүлээхгүй", мөн зүйлийн 3 дахь хэсэгт "Яллагдагчийг өөрийнх нь эсрэг мэдүүлэг авахаар албадахыг хориглоно" гэж тус тус заасан яллагдагч, шүүгдэгчийн эрхийг ноцтой зөрчихөд хүргэнэ. (27)
 9. **Иймд шүүхийн шийдвэрийн үндэслэл болсон сэтгэцийн шинжилгээний 272 тоот дүгнэлтийн шинжлүүлэгчээс хэргийн талаар ярьсан хэсгийг нотлох баримтаар тооцох хууль зүйн үндэслэлгүй болно.** (28)
 10. Хэргийн бодит байдлыг тогтооход гарсан эргэлзээг арилгах зорилгоор мөрдөн байцаалтын дутуу ажиллагааг нөхөн гүйцэтгүүлэх, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зөрчлийг арилгуулах, зөвтгүүлэх, хэргийн үйл баримтыг хөдөлбөргүй тогтооход шаардагдах нотлох баримтын хүрэлцээт байдлыг хангуулсны эцэст гэм буруугийн талаар шүүхээс үнэлэлт, дүгнэлт өгөх боломж, нөхцөл бүрдэх тул шийтгэх тогтоол, магадлалыг хүчингүй болгож шийдвэрлэв. (29)

---oOo---

³ "Хууль хэрэглээ, шүүхийн шийдвэр" хэсгийн өгүүлбэрийн төгсгөлд бичигдсэн хаалт доторх дугаарлалт нь шүүхийн эх шийдвэрийн цогцолборын дугаар болно.